БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: БУА-2020/34/СТА-ТШЗ

## БУЛГАН АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН 2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**Гурванбулаг сум 2020 он**

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр

Утас: 70342580 Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 70342729 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn

Аудитор: Б.Энхтөр

Утас: 70342729 Цахим хаяг: Enkhturb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

# Агуулга

1 Аудитын гэрчилгээ 3
2 Аудитын тайлан 5
2.1 Оршил ........ 5
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ........ 5
2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ........ 6
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ........ 6
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ........ 7
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ........ 8
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ........ 8
2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ........ 8
2.8.1 Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....10
2.9 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ........ 10
2.10 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ........ 10
2.11. Шилэн дансны мэдээлэл ........ 11
2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ........ 11
2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ........ 11
3 Менежментийн захидал 12
4 Аудит хийсэн санхүүгийн тайлан 14

# 1 Аудитын гэрчилгээ

БУЛГАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2020.02.03 № 24

танай ____________-ны № ____________ т

БУЛГАН АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Б.НАРАНТУНГАЛАГ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, заавраар дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

006020042

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Захирал Б.Нарантунгалаг-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 30-наас 2020 оны 02 дугаар сарын 04–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймгийн аудитын газрын аудитор Б.Энхтөр хариуцаж хэрэгжүүлэв.

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн аудитын газар-т 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 19 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

## 2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, A101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль нь Хүмүүнлэг, Оюунлаг, чадварлаг иргэний төлөө гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Ерөнхий боловсрол олгох  үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Бага боловсрол
- Дунд боловсрол
- Бүрэн дунд боловсрол олгох үйл ажиллагааны чиглэлтэй

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Засгийн газрын тогтоол шийдвэрүүд.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

- Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоол “Журам батлах тухай”
- Засгийн газрын оны 6 дугаар тогтоол “Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам”
- Засгийн газрын оны 24, 25 дугаар тогтоолууд
- Засгийн газрын оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”
- Засгийн газрын оны 275 дугаар тогтоол “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай”
- Засгийн газрын оны 276 дугаар тогтоол “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг шинэчлэн тогтоох тухай

Ёс зүйн хороог шинэчилж холбогдох дүрэм журмыг хангаж, өмч хамгаалах зөвлөлийг байнга ажиллуулж байна .

### 2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах  гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Си Ти Эс” программ хангамж ашигладаг байна.

дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт Үр нөлөөтэй гэж үзлээ.

### 2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 11 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 2 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

### 2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр *Нийт зардал*-ын *1* хувиар сонгов.

*Нийт зардал*-г материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь Төсвийн хүрээнд зардлын ангиллаар зарцуулалт хийх, сургуулийн хувьд суурь үзүүлэлтийг сонгож ажиллах нь зүйтэй. -холбоотой юм.

2019 оны *Нийт зардал* 9,649.69 мянган төгрөг бөгөөд түүний *1* хувь болох *9,649.69* мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг *1* хувиар тооцсон нь 1 холбоотой юм.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

### 2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 4 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 3 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг B501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж өгсөн | 0 | 0.00 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 1 | 2,136,909.90 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 2 | 3,849,656.00 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | Дүн | 3 | 5,986,565.90 | |

### 2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Тээвэр шатахуун

1.1 Илрүүлэлт:

Шатахууны зардлаас анхан шатны баримтгүй 2136.9 мянган төгрөгийг зарцуулсан.

1.2 Шийдвэрлэлт: Төлбөрийн акт тогтоосон.

### 2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Тээвэр шатахуун, Дотуур байрны хүүхдийн хоол, Үдийн цай хөтөлбөрийн хүнсний материалын зарцуулалтыг норм нормативын дагуу олгож хууль журмын дагуу ажиллах

Няравын анхан шатны баримтыг хууль журмын дагуу бүрдүүлэх, цэгцлэх

### 2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2019 онд 367.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 964.9 сая төгрөг буюу 98.61 хувьтай байгаа нь Жирэмсэн амаржсаны амралттай ажилчдаас болон цэвэр бохир ус хэмнэгдсэн. шалтгаалжээ.

3353206.48

**2.11. Шилэн дансны мэдээлэл**

Гурванбулаг сумын Ерөнхий боловсролын сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

**2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар Өмнөх онд зөвлөмж өгөөгүй хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

**2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

# 3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь  нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

## 3.1 Дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цай

3.1.1 Илрүүлэлт:

Дотуур байрын хүүхдийн хоол, үдийн цайнд 560.4 мянган төгрөгийг илүү зарцуулсан байна. Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэлүүд:

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 450 дугаар тогтоолын дагуу 2020 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжүүлж норм нормативын дагуу ажилласан 1-3 сарын тайлангаа ирүүлэх

3.1.4 Төсвийн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

## 3.2 Тээвэр шатахууны данс:

3..2.1 Илрүүлэлт:

Тээвэр шатахууны зардлаас анхан шатны баримтгүй 2136.9, анхан шатны баримт дутуу 3289.2 мянган төгрөгийн шатахууныг зарцуулсан байна. НББ тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй.

3.2.2 Эрсдэлүүд:

НББ-ийн тухай хуулийн холбогдох дүрэм журам зөрчигдөх, тайлан тэнцэл буруу илэрхийлэгдэх

3.2.3 Өгсөн зөвлөмж:

НББ тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7 дах  дугаар заалтыг хэрэгжүүлж ажиллах.

3.2.4 Төсвийн захирагчийн хариу:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дүгээр сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР Б.ЭНХТӨР

2020.02.03

# 4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **91,222,605.37** | **104,907,069.37** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 91,222,605.37 | 104,907,069.37 |
| **351** | **Түүхий эд материал** | 66,479,610.37 | 70,684,660.37 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 66,119,610.37 | 70,504,660.37 |
| 35130 | Эм боох материал | 360,000.00 | 180,000.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 1,970,060.00 | 3,258,320.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 18,913,935.00 | 27,213,089.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 8,505,107.00 | 8,479,007.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 7,075,350.00 | 12,501,600.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,333,478.00 | 6,232,482.00 |
| 35600 | Мал амьтад | 3,859,000.00 | 3,751,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,925,619,820.51** | **2,888,868,483.38** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 2,925,619,820.51 | 2,888,868,483.38 |
| **392** | **Биет хөрөнгө** | 2,868,081,820.51 | 2,831,330,483.38 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,604,870,299.82 | 3,830,170,299.82 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (1,106,574,627.34) | (1,133,534,880.82) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 166,137,176.79 | 173,474,916.79 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (99,889,085.97) | (118,385,869.01) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 86,959,720.23 | 92,869,720.23 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (46,025,104.13) | (51,284,244.74) |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | 2,225,300,000.00 | - |
| 39217 | Ном | 37,303,441.11 | 38,020,541.11 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 57,538,000.00 | 57,538,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 57,538,000.00 | 57,538,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,016,842,425.88** | **2,993,775,552.75** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,016,842,425.88** | **2,993,775,552.75** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,016,842,425.88 | 2,993,775,552.75 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,204,609,946.28 | 1,204,609,946.28 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 1,168,001,851.11 | 1,144,934,977.98 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,168,001,851.11 | 1,168,001,851.11 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (23,066,873.13) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 644,230,628.49 | 644,230,628.49 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,016,842,425.88** | **2,993,775,552.75** |

## 4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **766,667,064.00** | **941,902,500.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **165,707,264.00** | **4,391,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 165,707,264.00 | 4,391,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 165,707,264.00 | 4,391,000.00 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 151,491,600.00 | - |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,047,000.00 | - |
| 1E+06 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 13,168,664.00 | 4,391,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **600,959,800.00** | **42,441,600.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 599,750,500.00 | |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 533,758,900.00 | 937,311,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 65,991,600.00 | 895,069,900.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,209,300.00 | 200,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 200,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,209,300.00 | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | - | 42,241,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | 42,241,600.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **843,003,702.50** | **964,861,373.13** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **843,003,702.50** | **964,861,373.13** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 795,112,092.86 | 930,807,426.65 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 553,730,110.36 | 702,279,017.52 |
| 210101 | Үндсэн цалин | 380,545,446.77 | 477,797,817.52 |
| 210102 | Нэмэгдэл | 121,041,676.59 | 114,495,644.00 |
| 210104 | Урамшуулал | 52,142,987.00 | 109,985,556.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 65,669,400.00 | 88,039,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 35,917,737.00 | 59,866,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 10,308,965.00 | 7,043,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,671,974.53 | 5,634,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,296,092.95 | 1,408,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,474,630.52 | 14,086,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,654,060.00 | 35,618,346.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,825,000.00 | 7,283,053.00 |
| 210302 | Түлш, халаалт | 15,829,060.00 | 28,335,293.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 18,760,570.00 | 8,867,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 841,060.00 | 922,700.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 13,303,570.00 | 6,098,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 442,400.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 51,400.00 | 41,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 80,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,484,540.00 | 1,241,900.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 20,296,902.50 | 21,390,476.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 62,500.00 | 317,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 17,776,802.50 | 19,411,176.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,457,600.00 | 1,661,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 8,357,780.00 | 1,460,100.00 |
| 210604 | Урсгал засвар | 8,357,780.00 | 1,460,100.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 404,800.00 | 406,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 404,800.00 | 406,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,175,000.00 | 15,494,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,175,000.00 | 15,398,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 96,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 104,063,470.00 | 57,251,787.13 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 2,175,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,137,800.00 | 4,360,610.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 102,925,670.00 | 50,716,177.13 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 47,891,609.64 | 34,053,946.48 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 47,855,280.00 | 30,700,740.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 25,455,480.00 | 29,703,740.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,696,000.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 6,703,800.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 997,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 36,329.64 | 3,353,206.48 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 36,329.64 | 3,353,206.48 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(76,336,638.50)** | **(22,958,873.13)** |
| 225 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 104,495,821.48 | 108,000.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 104,495,821.48 | 108,000.00 |
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (104,495,821.48) | (108,000.00) |
| 5 | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(180,832,459.98)** | **(23,066,873.13)** |

## 4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **767,729,842.00** | **937,511,500.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **152,538,600.00** | **-** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | 152,538,600.00 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 152,538,600.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 151,491,600.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,047,000.00 | - |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **615,191,242.00** | **937,511,500.00** |
| 1310 | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 599,750,500.00 | 937,311,500.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 533,758,900.00 | 937,311,500.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 65,991,600.00 | - |
| 1311 | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 1,209,300.00 | 200,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 200,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,209,300.00 | - |
| 1340 | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 14,231,442.00 | - |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 14,231,442.00 | - |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **767,729,842.00** | **927,937,660.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **767,729,842.00** | **927,937,660.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **705,222,500.36** | **892,577,453.52** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 553,730,110.36 | 702,279,017.52 |
| 210101 | Үндсэн цалин | 384,546,501.46 | 477,497,817.52 |
| 210102 | Нэмэгдэл | 116,916,621.90 | 119,883,300.00 |
| 210104 | Урамшуулал | 52,266,987.00 | 104,897,900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 65,669,400.00 | 88,039,300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,745,737.00 | 59,866,700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 6,480,965.00 | 7,043,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,671,974.53 | 5,634,500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,296,092.95 | 1,408,600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,474,630.52 | 14,086,400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 33,280,000.00 | 40,197,296.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,825,000.00 | 7,200,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 26,455,000.00 | 32,997,296.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,981,390.00 | 8,745,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 563,460.00 | 544,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 4,651,800.00 | 6,946,100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 431,400.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 694,170.00 | 82,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 80,000.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,991,960.00 | 621,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 21,288,170.00 | 24,293,480.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 422,500.00 | 137,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | 19,200,270.00 | 22,292,180.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,665,400.00 | 1,863,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 12,821,800.00 | 1,177,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 12,821,800.00 | 1,177,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 404,800.00 | 406,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 404,800.00 | 406,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,325,000.00 | 15,301,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,325,000.00 | 15,205,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | - | 96,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 3,721,830.00 | 12,137,460.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 2,220,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,721,830.00 | 9,917,160.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **62,507,341.64** | **35,360,206.48** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 62,471,012.00 | 32,007,000.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 14,231,442.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 25,839,770.00 | 31,010,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 15,696,000.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 6,703,800.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 997,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 36,329.64 | 3,353,206.48 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 36,329.64 | 3,353,206.48 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **9,573,840.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **9,573,840.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **9,573,840.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 9,573,840.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 9,573,840.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(9,573,840.00)** |

## 4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,147,071,946.28 | 477,498,806.01 | 1,296,221,432.01 | | 2,920,792,184.30 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | | | | - | - |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | 140,481,064.46 | | | 140,481,064.46 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 57,538,000.00 | | | | 57,538,000.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 1,115,386,672.03 | | 1,115,386,672.03 |
| C08 | **2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | | | | - | - |
| D01 | **2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **1,204,609,946.28** | **644,230,628.49** | **1,168,001,851.11** | - | 3,016,842,425.88 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **1,204,609,946.28** | **644,230,628.49** | **1,168,001,851.11** | - | 3,016,842,425.88 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | (23,066,873.13) | | (23,066,873.13) |
| D09 | **2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **1,204,609,946.28** | **644,230,628.49** | **1,144,934,977.98** | - | 2,993,775,552.75 |

## 4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

**/ төгрөгөөр /**

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 0.00 | 0.00 | 937511500.00 | 937511500.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 0.00 | 0.00 | 937511500.00 | 927937660.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 0.00 | 905166500.00 | 892577453.52 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 0.00 | 0.00 | 704314500.00 | 702279017.52 |
| 210101 | Үндсэн цалин | | | 479533300.00 | 477497817.52 |
| 210102 | Нэмэгдэл | | | 119883300.00 | 119883300.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | | 104897900.00 | 104897900.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 0.00 | 0.00 | 88039300.00 | 88039300.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | | 59866700.00 | 59866700.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | | 7043100.00 | 7043100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | | 5634500.00 | 5634500.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | | 1408600.00 | 1408600.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | | 14086400.00 | 14086400.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 0.00 | 0.00 | 41064000.00 | 40197296.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | | 7200000.00 | 7200000.00 |
| 210302 | Түлш, халаалт | | | 33000000.00 | 32997296.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | | 864000.00 | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 0.00 | 17467300.00 | 8745500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | | | 544200.00 | 544200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | | 6946100.00 | 6946100.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | | | 431,400.00 | 431,400.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | | 649,400.00 | 82,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | | 214,500.00 | 120,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | | 8,681,700.00 | 621,500.00 |
| **2105** | **Нормативт зардал** | - | - | 24,298,600.00 | 24,293,480.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | | 137,900.00 | 137,900.00 |
| 210502 | Хоол, хүнс | | | 22,297,300.00 | 22,292,180.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | | 1,863,400.00 | 1,863,400.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | - | 1,177,600.00 | 1,177,600.00 |
| 210604 | Урсгал засвар | | | 1,177,600.00 | 1,177,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | - | 406,800.00 | 406,800.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210702 | Дотоод албан томилолт | | | 406,800.00 | 406,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | - | 15,464,400.00 | 15,301,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | | 15,368,400.00 | 15,205,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | | | 96,000.00 | 96,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | - | 12,934,000.00 | 12,137,460.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | | 2,300,000.00 | 2,220,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | | | 10,634,000.00 | 9,917,160.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | - | 32,345,000.00 | 35,360,206.48 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | - | 32,345,000.00 | 35,360,206.48 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | | | 31,010,000.00 | 31,010,000.00 |
| 213503 | Төвлөрүүлэх Шилжүүлэг | | | | 3,353,206.48 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | | 1,335,000.00 | 997,000.00 |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | - | - | **9,573,840.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | - | - | 9,573,840.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | | | | 9,573,840.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | | | |